Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд |

² Чанарынбаталгаатхугацаагтогоохдоо Иргэнийхууль болон Барилгын тухайхуулийг баримтална.

**гологдол
арилгахгүй
байх**

заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

**11. Үе шатны
ажлын
хуваарь**

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

**12. Үе шатны
ажлын
хуваарийг
өөрчлөх**

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги³ төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах

14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

15. Хүлээж авах

15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

**16. Эцсийн
тооцоо**

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанаарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт,
засвар,
үйлчилгээний
гарын авлагা**

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

³ Алдангийг хийхэвчлэнхоногт 0.05-0.10 хувиартогтоох бөгөөдний түннэгэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх толбөр

- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар:
ГЕН 2.1	Ажил нь захиалагчаас ирүүлсэн хянан баталгаа хийлгэсэн зураг, төсөв-аас бүрдэнэ.
	Ажлын талбай нь _____-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: 201 оны сарын -ны өдөр Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 201 оны сарын -ны өдөр ⁵
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.1 хувь байна. ⁶ Алдангийг гэрээний үнийн дүнгийн гүйцэтгэлийн үлдэгдлээс алданга тооцох. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна. Алдангийн дээд хэмжээг гэрээний үнийн дүнгийн гүйцэтгэлийн үлдэгдлээс алданга тооцох.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 201 оны дугаар сарын -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 201 оны дугаар сарын -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200,000 төгрөг байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 10 хувиар тооцно.

4

Захиалгчтөндерийнбаримтбичгийг тараахаас сөмнөгэрээний туслайн нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалгчийн гаргах хувваарь, тайланг гэрээний туслайн нөхцөлд хувсаргана.

5

Ажлыг хэсэгчлэн дуусгахаарт төлөвлөсөн бол эдгээрх угагжааг жагсаана.

6

Ажлыг хэсэгчлэн дуусгахаарт болон хэсэг бүрт алдангих эргэглэх бол энд туслана.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

.....ДАРГА

Н.БАТМОНХ

(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

“,,,,,,,” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

.....”
(Гарын үсэг)

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № ХӨ-2020/.....-A/01

Хөвсгөл аймаг

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас *Хөвсгөл аймгийн Засаг дарга*(цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас(цаашид “түйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилсан тохиролцож „,, оны „,, дугаар сарын „,, -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “тэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилсан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь,.....-г (цаашид “ажил” гэх)
XӨ-201..-A/-г (цаашид “ажил” гэх)
.....(цаашид “тэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дун:....., төгрөг. Үнээс :

Үнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
201... онд:....., төгрөг;
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
201.. онд:, төгрөг;

4. Гүйцэтгэгч нь байршилтай
..... ажлыг 201.. оны „,, дугаар сарын „,-ны өдөр эхэлж, 201.. оны „,, дүгээр сарын „,-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Тендер;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт;
Зураг;
Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваар⁷:
Санхүүжилтийн хуваарь;
Ажил гүйцэтгэх хуваарь.

⁷ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

Бусад шаардлагатай баримт бичиг⁸;
Гүйцэтгэлийн баталгаа: „„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„“, дугаартай
гүйцэтгэлийн баталгаа, „„„„„„„„„„„„„„„„„“,
(„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„) төгрөг.

1.5. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

1.6. Захиалагч талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ харилцан хүндэтгэлтэйгээр асуудалд хандаж, хэн нэг нь давуу эрх эдлэхгүйгээр хамтын шийдвэр гаргаж ажиллана.

1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

1.10. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл бий болсноос бусад тохиолдолд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг сунгаж өөрчлөхийг хориглоно.

1.11. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

1.12. Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, ажлын too хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.

1.13. Гүйцэтгэгчид олгох гэрээний төлбөрөөс дараах зардлуудыг захиалагчийн холбогдох дансанд суутгана. Үүнд:

- Зураг төсөв, инженер геологи, эксперт үнэ: „„„“, төгрөг
 - Захиалагчийн хяналтын зардал: „„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„“, төгрөг
 - Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал: „„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„„“, төгрөг
 - Магадлашгүй ажил: „„„„„„„„„„„„„„„„„„„„“, төгрөг
 - Барилга байгууламжийн норм, нормативын сан „„„„„„„„„„„„„“, төгрөг
- Зураг төсөвт тусгагдаагүй болзошгүй ажлын зардлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлж болно.

ХОЁР: ЗАХИАЛАГЧ (ТӨСЛИЙН БАГИЙН) БОЛОН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1 Захиалагч нь “Барилгын тухай” хуулийн 37 дугаар зүйл болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолд тус тус заасан чиг үүргийг заавал хэрэгжүүлнэ.

2.2 Төслийн менежер нь гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчнийг, эсхүл төслийн төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчнийг ажиллуулна. Голлох мэргэжилтнийг өөрчлөх тухай гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг зөвхөн санал болгож буй орлох мэргэжилтний чадвар нь дээрх хуваарьт заасан шаардлагын түвшинд, эсхүл түүнээс өндөр түвшинд байх нөхцөлд төслийн баг зөвшөөрч батлана.

2.3 Төслийн менежер нь барилгын үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэх гэрээг зохиогч, төслийн багийн гишүүд, эсхүл зөвлөх багтай “Барилгын тухай” хуулийн 33.1.20-д заасан гэрээний загварааргэрээ байгуулан барилга угсралтын ажлын бүх үе шатанд ажлын журнал хөтлөн ажил бүр дээр чанар болон технологийн хяналтыг хийж захиалагчийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.

2.4. Барилга байгууламжийн үндсэн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулах, материалын гарал үүсэл, тохиролын гэрчилгээг хянах замаар үнэлэлт дүгнэлт гаргах, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн актуудыг баталгаажуулах:

2.5 Барилгын үйл ажиллагаанд холбогдох барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох зардлыг хариуцах,

⁸ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

2.6 Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гарсан хохиролыг хариуцах

2.7. Барилгын ажилд зураг төсөлд зааснаас өөр материалыг хэрэглэх тохиолдолд захиалагчийн болон зураг төсөл боловсруулсан зохиогчоос зөвшөөрлийг авч, зохих журмаар шинжилгээ, туршилт хийлгэж чанар, стандартын албан ёсны баталгаажилт хийлгэсний үндсэн дээр бүтээцийг өөрчлөхгүйгээр шийдвэрлэх:

2.8. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг батлагдсан зураг төсөл, норм, дүрэм техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх, гэрээг цуцлах эрхийг захиалагчийн томилсон төслийн менежер хэрэгжүүлнэ

2.9 Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулах

2.10 Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг дүгнэх, барилга, байгууламж, ажил үйлчилгээг ашиглалтад хүлээн авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах.

2.11. Чанарын баталгааны хугацаанд тухайн бараа, ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол, эвдрэл гараагүй болон зөрчил гологдлыг арилгасан тухай захиалагчийн томилсон ажлын хэсгийн акт, захиалагчийн мэдэгдлийг үндэслэн барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгох.

2.12. Төслийн менежер нь ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явцын талаарх дараах мэдээллийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт улирал бүрийн дараа сарын 1-ний өдөрт багтаан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

- гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчиний мэдээлэл

- Ажил худалдан авах гэрээний хэрэгжилтийн явц, үр дүн, гэрээ дүгнэсэн акт

- Ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, үе шатны ажлын гүйцэтгэл

- Барилгад ашигласан материал, хийц, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, дүгнэлт, гарал үүслийн гэрчилгээ

- Барилгын талбайд ажиллаж байгаа инженер техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын судалгаа

- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт,

- Барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл

- Захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт

- Тоног төхөөрөмж угсарсан актууд, холбогдох байгууллагаар баталгаажуулсан тоног төхөөрөмжийн туршилтын баримт бичиг, туршилт тохируулгын акт

- Санхүүжилтийн талаарх мэдээлэл

- Бусад шаардлагатай мэдээлэл

2.13 Захиалагчийн санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, барилга угсралтын ажлын зураг төсвийг захиалагчийн болон зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөн гүйцэтгэх, гэрээний нөхцөл, төсөв, норм дүрмийг зөрчиж ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, гарал үүсэл, тохиролын гэрчилгээгүй материал, хийц бүтээцийг ашигласан, мэргэжлийн байгуулагуудын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч санхүүжилтийг зогсоох, гүйцэтгэгчээс татгалзах, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүртэлх арга хэмжээг авч, учирсан хохирлыг төлүүлэх эрх өдөлнэ.

ГУРАВ: ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч нь “Барилгын тухай” хуулийн 40 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, барилгын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөх, хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулах, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, байгаль орчин, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2 Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд дурдсан голлох мэргэжилтний хуваарьт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчинийг, эсхүл төслийн багаас зөвшөөрсөн бусад ажиллах хүчинийг ажиллуулна. Голлох мэргэжилтний хуваарьт заасан ажиллах хүчинийг өөрчлөх тухай хүсэлтийг төслийн багт гаргаж шийдвэрлүүлнэ.

3.3 Барилгын ажлыг магадлал хийгдсэн, баталгаажсан зураг төсөл, норм нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих, ил далд ажлын акт, үе шатны ажлын тэмдэглэл, үе шатны ажлыг гэрээнд заасан хугацаанд багтаан гүйцэтгэж, гүйцэтгэлийг захиалагчаар батлуулах, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, ажлын явцад илэрсэн гологдол, зөрчлийг тухай бүрт нь

арилгаж, буруу, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр нөхөн гүйцэтгэх зэрэг чиг үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

3.4 Далд ажлын акт үйлдэн фото зураг /ажил эхлэхээс өмнө, ажил гүйцэтгэх явц, ажил дууссаны дараах байдлаар харьцуулсан/ болон гүйцэтгэлийн схем зургаар баталгаажуулж гүйцэтгэлд хавсаргах, давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюуллаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3.5 Ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр, гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай баталгааг гаргаж захиалагчид ирүүлэх

3.6 Гүйцэтгэгч нь Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу барилгын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөх бэтгэл ажлыг хангах, гэрээг захиалагчтай хамтран дүгнэх үүрэгтэй

3.7Үе шатны ажлын хуваарыт заасан үйл ажиллагааны гүйцэтгэлд нийцсэн санхүүжилтийн хуваарийг гаргаж захиалагчаар баталуулна.

3.8Барилгын ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангасан, гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, үйлдвэрлэгчийн баталгаа бүхий барилгын материалыг захиалагчтай зөвшилцэн ашиглах, суурилуулах

3.9 Барилгын үйл ажиллагаанд оролцогчдын төлөөллийг барилгын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх, барилгын зураг төсөл, баримт бичигтэй чөлөөтэй танилцах боломж олгох,

3.10Барилга байгууламжийн ашиглалтын зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдэл эс үйлдхүүн улмаас үүсэн хохиролыг хариуцах, ажлын талбайд хариуцан хүлээн авсан бүх эд хөрөнгийн бүрэн хариуцлагыг хүлээх

3.11 Барилга байгууламж барих, шинэчлэх засварлахдаа, зам, гудамж, талбай сэтэлж эвдэлсэн, мод, цэцэрлэгжүүлэлтийг зайлдуулсан бол тэдгээрийг нөхөн сэргээх

3.12 Барилгын ажилд ашигласан барилгын материал, тоног төхөөрөмж зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг захиалагчийн барилга техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт, гарал үүсэл, тохиролын гэрчилгээ”-г үе шатны ажил эхлэхээс /уг материалыг хэрэглэхээс/ өмнө захиалагчаар хянуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр дараагийн үе шатны ажилд ашиглана.

3.13 Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийг Төрийн сан банкны 100170051305 тоот дансанд уг баталгааны хугацааг дуустал байршуулна. Барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс эхлэн чанарын баталгааны хугацааг тооцно.

3.14. Гүйцэтгэгч компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний нэр, гэрээний үнийн дүн санхүүжилтийн хуваарь, ажил, эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин болон тухайн объектийн байрлах газарт олон нийтэд үзэгдэхүйцээр уг ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацааны туршид заавал байршуулна.

3.15 Барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрт лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан захиалагчаар батлуулах,

3.16 Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгч, түншлэгч ажиллуулахаар тендертээ ирүүлж, тэднээр барилгын ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд түншлэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдлийг захиалагчийн өмнө хариуцах ба тендертээ туслан гүйцэтгэгч, түншлэгч ажиллуулахаар санал ирүүлээгүй тохиолдолд түншлэгч, туслан гүйцэтгэгч ажиллуулахыг хориглоно.

3.17 Далд ажлын акт үйлдэн фото зураг /ажил эхлэхээс өмнө, ажил гүйцэтгэх явц, ажил дууссаны дараах байдлаар харьцуулсан/ болон гүйцэтгэлийн схем зургаар баталгаажуулж гүйцэтгэлд хавсаргах үүрэгтэй.

3.18 Барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж захиалагч, зохиогчоор батлуулах

3.19 Барилга, байгууламж, ажил, үйлчилгээг ашиглалтанд хүлээн авах, болон туршилт тохируулга хийсэн тухай акт зэрэг баримт бичиг албан ёсоор баталгаажаагүй, барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авах тухай шийдвэргараагүй байх хугацаан дахь тухайн барилга, байгууламжийн ашиглалт үйлчилгээтэй холбоотой урсгал зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

ДӨРӨВ: АЖИЛ, МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	материалын нэр, марк	Хэмжих нэгж	тоо ширхэг	Нэгж үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	үйлдвэрлэсэн улс	техникийн тодорхойлолт, холбогдох стандарт

ТАВ: АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

Ажлын үе шатны хуваарийн доорх хүснэгтээр гаргав.

д/д	Гүйцэтгэх ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	тоо	Төсөвт өртөг /мян.төг/	сар	12 сар			2018-04			Дүн
					10 хоног	1	2	3	1	2	3	
1					Төл							
					Гүйц							
2					Төл							
					Гүйц							
3					Төл							
					Гүйц							

Санхүүжилтын хуваарийг доорх хүснэгтээр гаргав.

Д/Д	Барилга байгууламжын нэр	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих	2018 онд санхүүжих

ЗУРГАА: БАРИЛГЫН АЖИЛД АШИГЛАХ МОНГОЛ УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭЦ ХИЙЦИЙН ЖАГСААЛТ

№	Бараа, материал, бүтээц хийцийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо	Нийт үнэ /мян төг/	Үйлдвэрлэгч нийлүүлэгчийн нэр

ДОЛОО: АЖИЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.0: Хөвсгөл аймгийн Засаг дарга, ,,,,,,, ажил, ХӨ-2018/,,,,,-A/01

ГЕН 2.1: Ажил нь дараах иж бүрдлээс бүрдэнэ: Ажил нь захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлол, зураг төсөв, гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерээс бүрдэнэ.

ГЕН 3.0: Гэрээний хэл: Монгол хэл байна.

ГЕН 4.0: Төслийн менежер: Хөвсгөл аймгийн Засаг даргын 2018 оны А/,,,, тоот захирамжаар томилсон төслийн менежерийн багийг төлөөлж, аймгийн ,,,,,,, ажилтай ,,,,,,,.

ГЕН 9.1: Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон голлох мэргэжилтний хуваарыт заасан ажил үүрэг бүхий ажиллах хүчний танилцуулга, мэдээлэл: /Ажилтны нэр, мэргэжил, албан тушаал, хариуцах ажил, гүйцэтгэх үүрэг гэсэн мэдээллэээр гаргасан байна./

ГЕН 17.1: Ажил эхлэх, дуусах хугацаа: Ажил 2018 оны,,, дугаар сарын ,,-ны дотор эхэлж, 2018 оны ,,, дүгээр сарын ,,-ны өдрийн дотор ашиглалтанд орсон байна.

ГЕН 18.1 Гүйцэтгэгч туслах ажлын зураг техникийн тодорхойлолт, зургыг гарган төслийн менежерт ирүүлэх ба гэрээний срөнхий нөхцлийн 18-д зааснаар туслах ажлын техникийн тодорхойлолт, зураг төслийг батлах ба шаардлагатай бол гүйцэтгэгч зураг, төсөлд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

ГЕН 25.1: Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны өрөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дараа гэрээ байгуулах өдрөөс өмнө төслийн менежерт хүргүүлж батлуулсан байна.

ГЕН 25.2: Захиалагчийн томилсон төслийн баг ажлын үе шатны хяналтыг хийж, төслийн менежер, аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөл, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас төслийн багт томилогдсон хяналтын инженер, гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, зураг төсөл зохиогч, аймгийн онцгой байдлын газрын холбогдох улсын байцаагч зэрэг албан тушаалтууд ил далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг, барилгын ажилд хэрэглэсэн барилгын материалын техникийн тодорхойлолт, ажлын гүйцэтгэл зэрэг баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулна.

ГЕН 32.1: Чанарын баталгааны хугацаа: Ажлыг ашиглалтанд хүлээн авсан өдрөөс хойш барилга байгууламжийн зүгшрүүлэх тохируулах хугацаа 1 жил байна. Гүйцэтгэгч зөрчил гологдлыг арилгаагүй нөхцөлд, зөрчил гологдол арилгаж дуусах хүртэл хугацаагаар чанарын баталгааны хугацааг захиалагч сунгана.

ГЕН 32.2: Барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц бүтээц, бохир ус, уур хий, дулаан цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын 3 жилийн хугацаанд дээрх барилга байгууламж, засал, материал, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, чанаргүй гүйцэтгэлийг гүйцэтгэгч хариуцан засварлана.

ГЕН 32.3: Улс, Орон нутгийн төсөв, Гадаадын зээл тусlamжийн хөрөнгөөр санхүүжих барилга байгууламжинд барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д заасан гүйцэтгэгчээс хүлээх Үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацааг дуустал захиалагч барьцаална.

ГЕН 34.1: Гүйцэтгэгч нь үе шатны ажлын тодотгосон хуваарийг гэрээ байгуулж, баталгаажуулах өдрөөс өмнө Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын хавсралт маягтын дагуу боловсруулж төслийн менежерт ирүүлж, төслийн менежерийн саналыг тусган сайжруулах үүрэг хүлээх бөгөөд үе шатны ажлын хуваарын тусгасан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаатай нийцсэн байна.

ГЕН 39.1: Гэрээний төлбөрийг Сангийн сайдын 2016 оны 415 дүгээр тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэл 60 дээш хувийн биелэлтэйтохиолдолд гэрээнийн үнийн дүнгийн 50 хүртэл хувьтай тэнцэх санхүүжилтийг, ажил бүрэн дуусаж, барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсны дараа гэрээний үлдэгдэл төлбөр болох 50 хувийн санхүүжилтийг тус тус олгоно.

ГЕН 40.1: Гүйцэтгэгч гэрээний эцсийн гүйцэтгэлийн тооцоог төслийн менежерт ирүүлж, батлуулан холбогдох баримт бичгийг захиалагчид ирүүлснээс хойш 30 хонгийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хоцруулсан төлбөрт 0,1 хувийн торгуулийг дараагийн төлбөртэй хамт төлөх буюу торгуулийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.

ГЕН 45.1: Захиалагч гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн эцсийн санхүүжилтээс гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх хэсгийгчанарын баталгааны барьцаа хөрөнгө болгон захиалагчийн дансанд суутгаж үлдээнэ. Чанарын баталгааны хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай болон гологдол зөрчил гараагүй тухай мэдэгдлийг үндэслэн чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид олгоно.

ГЕН 45.3: Магадлашгүй ажлыг гүйцэтгэх эсэх шийдвэрийг захиалагч /төслийн баг/ гаргах бөгөөд магадлашгүй ажил гүйцэтгэх ажлын зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог захиалагчийн сонгосон зөвлөх гүйцэтгэж, түүнд эрх бүхий этгээд магадлалын дүгнэлт гаргасан байна. Дээрх шаардлагыг хангасан зураг төслиөөр гүйцэтгэсэн магадлашгүй ажлыг магадлашгүй ажлын зардаас санхүүжүүлнэ.

ГЕН 46.1: Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй.

ГЕН 52.1: Гүйцэтгэгч ажлын явцад зам, талбай, гудамж сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол барилга ашиглалтанд хүлээн авахаас өмнө тэдгээрийг сэргээсэн байна. Нөхөн сэргээлт хийгээгүй тохиолдолд барилга ашиглалтанд хүлээн авахыг хориглоно.

ГЕН 55.1: Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагчийн шаардсан ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага, барилгын ажлын архив, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.9-д заасан мэдээллийн самбар зэргийг 201 оны „„ дугаар сарын „„-ны өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрөөс гэрээний үнийн дунгийн 5 хувьтай тэнцэх мөнгийг захиалагчийн дансанд суутган үлдээнэ.

НАЙМ: ХАРИУЦЛАГА

- 8.1. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.
- 8.2. Талууд бие биснийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- 8.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.
- 8.4. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргахаа бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.
- 8.5. Төсвийн орлогын бүрдэлтээс шалтгаалсан төлбөрийн saatlyg санхүүжүүлэгч хариуцахгүй.
- 8.6. Барилгын тухай хуулийн холбогдох заалт болон энэ гэрээг зөрчсөн тал барилгын тухай хуулийн 50, Иргэний хуулийн 352, 353, 354, 355 дугаар зүйлүүдэд заасан үүрэг хариуцлагыг хүлээнэ.
- 8.7. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцэж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 9.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 9.2. Энэхүү гэрээний нөхцөлд гэрээний үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

АРАВ: ГЭРЭЭ ДҮГНЭХ

- 10.1. Захиалагчийн төслийн баг болон гүйцэтгэгч байгууллага хамтран ажил гүйцэтгэх гэрээг дүгнэнэ.
- 10.2. Барилга угсралтын ажлын үндсэн гэрээ болон нэмэлт гэрээг тухайн үе шатанд хийгдсэн ажлын гүйцэтгэл, гэрээний бусад нөхцлийг үндэслэн дүгнэнэ.
- 10.3. Барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан тохиолдолд төслийн баг, гүйцэтгэгч, ашиглагч, зохиогч хамтран уг барилга багууламжид үзлэг шалгалт хийн техник хяналтын нэгдсэн дүгнэлт, байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулах тухай хүсэлт зэргийг аймгийн засаг даргад ирүүлэх ба аймгийн засаг дарга барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс томилсон шийдвэр гаргана.